

## МНТ-Д БУЙ УС, ГОЛ, МӨРӨН ЗЭРГИЙН ОНООСОН НЭРИЙН ФРАНЦ ОРЧУУЛГА

Н. Мөнх<sup>37</sup>

**Аннотация:** Французский перевод “Сокровенного сказания монголов” является особенным и важным источником, в котором переводчики перевели большинство имён собственных. Хотя с одной стороны дословный и смысловой переводы имён собственных, особенно антропонимов, в основном противоречат практике перевода, с другой стороны это является важным шагом в изучении имён собственных средневекового монгольского языка. В данном Сокровенном сказании мы нашли 49 гидронимов и провели краткое изучение особенностей их перевода на французский язык.

**Түлхүүр үг:** МНТ, нэр, нуур, мөрөн, гол, горхи, ус

МНТ-д 1000 орчим оноосон нэр байдаг хэмээн судлаачид үздэг бөгөөд Мари-Доминик Эвен, Родика Поп нарын 1994 онд ЮНЕСКО-гийн төслийн хүрээнд гүйцэтгэсэн франц орчуулгад утга, гарвацийг нь тогтоосон оноосон нэрсийг үгчлэн, утгачлан орчуулсан байдаг. Бид энэ удаад *hydronym* буюу усны зүйлийн оноосон нэрийг франц хэлнээ хэрхэн орчуулсанд ажиглалт хийхээр зорилоо. Бид МНТ-ы олдмол эх, Ш. Чоймаа багшийн монгол орчуулга, Л. Лигеттигийн латин галиг, 1994 оны франц орчуулга зэргийг нэгбүрчлэн шүүж нийт 49 усны зүйлийн нэр оллоо:

1. Alqui bulaq-Алхуй булаг, la Source-des-Salsepareilles /阿勒<sup>中</sup>灰不刺-ā l(è) hueī rù lā/. §141. Уг оноосон нэрийг франц хэлнээ үгчилж орчуулсан байна. *Алхуй* гэдгийг халм. *alūi* гэдэг эмийн ургамлаас үүдэлтэй нэр хэмээн үзээд Salsepareilles гэж үгчлэн орчуулжээ. *Булаг* гэдгийг мөн үгчлэн source гэж буулгасан байна.
2. Алтан горхи, le ruisseau d’ Or /阿勒<sup>中</sup>壇<sup>中</sup>豁<sup>中</sup>羅<sup>中</sup>罕- ā l(è) t’án huō rá hān/. §259. Орчуулагчид нэрийг франц хэлнээ *ruisseau* ‘горхи’, *or* ‘алт’ гэж үгчлэн орчуулсан.
3. Amui müren-Амуй мөрөн, l’Amou-Daria /阿梅<sup>中</sup>沐<sup>中</sup>漣-ā muéi mù rién /. §258. Орчуулагчид уг нэрийг франц нэршлээр нь орчуулсан байна.
4. Ariq usun-Ариг усан, la rivière Limpide /阿<sup>中</sup>里<sup>中</sup>兀<sup>中</sup>孫-ā rī h(ei) wu sūn/. §§8, 9. Франц орчуулгад *Ариг* хэмээх оноосон нэрийг үгчлэн орчуулсан байна: *limpide* ‘тунгалаг, цэвэр’ (Ариг гэдгийн тухайд *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*, I, т. 137а үзнэ үү). *Ус* гэдэг үгийг *rivière* ‘гол’ гэж орчуулжээ. Судлаач И. де Рахевильц уг үгийг устай газрыг заадаг үг хэдий ч гол гэж орчуулах боломжтой юм гэсэн байдаг<sup>38</sup>. Эрдэмтэн Х. Пэрлээ уг

<sup>37</sup> Доктор, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбарын Европ судлалын тэнхим

<sup>38</sup> I. de Rachewiltz, *The Secret History of the Mongols A Mongolian Epic Chronicle of the XIII century*, Vol. I, Brill Leiden-Boston, 2004, т. 248.

- голын байршлыг тогтоож, Хөвсгөл нуураас зүүн тийш орших өнөөгийн Аригийн гол гэжээ<sup>39</sup>.
5. Baydaraq-*Байдараг*(гол), la rivière Baidaraq /巴亦荅刺-*pā yì tā rā h(ei)*/. §159. Уг гол нь Хангайн нурууны өмнө хэсэгт орших<sup>40</sup> бөгөөд орчуулагчид эл голын нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
  6. Baljuna na'ur-*Балжуна нуур*, Le lac du Marécage /巴勒渚納納浯兒-*pā l(è) chǔ nà nà wú ér*/. §§182, 183, 208. Х. Пэрлээ, П. Пеллио, Н. Поппе зэрэг нэрт судлаачид уг нуурын байршлыг өөр өөрөөр тодорхойлсон байдаг байна. Франц хэлнээ уг нэрийг үгчлэн *Marécage* ‘намаг’ гэж орчуулсан байна.
  7. Buqdurma huja'ur-*Бухдурма узуур*, la Buqtarma /不都兒麻忽札兀兒-*pù h(ei) tūo ér má hū chá wù ér*/. §198. *Бухтарма* хэмээх гол өнөөгийн Казахстан улсын нутагт байдаг байна. Уг голын нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгаж *huja'ur* гэдэг үгийг орхисон байна.
  8. Buuyur na'ur-*Буйр нуур*, Le lac Buir /捕魚兒納浯兒-*pǔ yú ér nà wú ér*/. §53. Дорнод аймгийн Халхгол суманд байх уг нуурын нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
  9. Čui müren-*Чуй/Чүй мөрөн*, la rivière Tchou /垂沐漣-*ch'uei mù tién* / . §§152,177, 198, 236. Судлаачид уг мөрөнг өнөөгийн Киргиз, Казахстаны нутагт урсдаг Чу мөрөн хэмээн тодорхойлдог байна. Франц хэлнээ уг нэрийг *Tchou* хэмээн галиглаж, харин мөрөн гэдэг үгийг *fleuve* ‘мөрөн’ гэж биш харин *rivière* ‘гол’ гэж орчуулжээ.
  10. Eke qoroqan-*Эх горхин*, le ruisseau de la Mère /額客豁羅罕-*é k'è huō rá hān*/. §257. МНТ-ы бичвэрээс үзэхэд уг горхи нь өнөөгийн Афганистаны зүүн болон Пакистаны зүүн хойд хэсэгт урсах Кабул голын цутгал байх магадлалтай. Франц хэлнээ нэрийг үгчлэн *Mère* ‘эх, ээж’ хэмээн орчуулжээ.
  11. Erdiš müren-*Эртиш* (Эрчис), l'Irtych /額兒的失沐漣-*é ér dì shǐ mù tién*/. §§198, 207, 264. Орчуулагчид *Эрчис* мөрний нэрийг франц хэлнээ тогтсон хувилбараар нь орчуулжээ.
  12. Ergüne müren-*Эргүнэ мөрөн*, le fleuve Argoun /額峒涅沐漣-*é ér kǔ niè mù tién*/. §§ 141, 144, 182. Монгол хэлнээ уг голын нэрийг *Эргүнэ*, бур. *Үргэн* ‘өргөн’, ор. *Аргунь* гэх бөгөөд франц хэлнээ орос дуудлагыг галиглаж хэвшсэн байдгийг орчуулагчид хэрэглэжээ.
  13. Ge'un qoroqan-*Гүүн горхин*, le ruisseau de la Jument /格溫豁羅罕-*ké uēn huō rá hān*/. §257. Эрдэмтэн, судлаач нар уг горхины байршлыг лавтай тогтоож чадаагүй хэдий ч энэ горхи нь Кабул голын урсац байх нь лавтай хэмээн үздэг ажээ. Орчуулагчид уг нэрийг монгол хэлний *гүү* хэмээх үгээс үүссэн гэж үзээд ийн үгчлэн орчуулсан байна.
  14. Güse'ur na'ur-*Гүсэгүр нуур*, Le lac Güse'ur /古薛兀兒納兀兒-*kǔ siè wù ér nà wú ér*/. §§151, 177. Нэрт эрдэмтэн Х. Пэрлээ уг нуурын байршлыг

<sup>39</sup> Х. Пэрлээ, *Монголын нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь*, УБ., 1958.

<sup>40</sup> Х. Пэрлээ, *Монголын нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь*, УБ., 1958.

- өнөөгийн Дорноговь аймгийн Гурван Хөвсгөл уул хавьцаа байсан гэж тогтоожээ. Франц орчуулгад уг оноосон нэрийг галиглан буулгажээ.
15. Hariltu na'ur-*Харилту нуур*, Le lac Ariltu /哈<sup>ᠬ</sup>灑<sup>ᠲᠤ</sup>禿<sup>ᠨᠠ</sup>渥<sup>ᠤ</sup>兒<sup>ᠷ</sup> -hā rī l(i) t'ü nà wú ér/. § 136. Судлаачид уг нуурын байршлын талаар санал зөрөлддөг байна. Францын нэрт монголч эрдэмтэн П. Пеллио уг нуурыг Хэрлэн голын сав газраас өмнө зүгт, харин монголын нэрт эрдэмтэн Х. Пэрлээ уг нуурыг Хэнтийн уулсын өмнөд этгээдэд оршдог хэмээн тус тус үзжээ. Нэрийн бичлэгийн тухайд ч эрдэмтэд нэг мөр болоогүй байна. Франц орчуулгад П. Пеллио гуайн тайлж уншсан хувилбарыг баримтлан галиглаж орчуулсан байна.
16. Idil müren-*Идил мөрөн* (Ижил), le fleuve Volga /亦<sup>ᠤ</sup>的<sup>ᠤ</sup>勒<sup>ᠮ</sup>洩<sup>ᠤ</sup>-yì dì l(è) mù ríén/. §§262, 270. Энэ мөрний нэрийг франц орчуулгад тогтсон хувилбараар нь буулгасан байна.
17. jāyag müren-*Жаяг мөрөн*, le fleuve Oural /扎<sup>ᠵ</sup>牙<sup>ᠮ</sup>洩<sup>ᠤ</sup>-chá iá h(ei) mù ríén/. §§262, 270. Эрдэмтэд *Жаяг* гэдэг нь өнөөгийн *Урал* мөрний нэр хэмээн үздэг бөгөөд франц орчуулгад тогтсон хувилбараар нь орчуулсан байна.
18. Kan müren-*Хан мөрөн*, la rivière Ken /刊<sup>ᠬ</sup>洩<sup>ᠤ</sup>-k'ān mù ríén/. §141. Мари-Доминик Эвен, Родика Поп нар уг голын нэрийг галиглан буулгасан байна. Бид уг нэрийг франц хэлнээ тогтсон хувилбар буюу **Gan** хэмээн орчуулах нь зүйтэй болов уу хэмээн үзэж байна.
19. Kelüren müren-*Хэрлэн мөрөн*, La rivière Kerülen /客<sup>ᠬ</sup>魯<sup>ᠮ</sup>洩<sup>ᠤ</sup>-k'è luò ríén mù ríén/. §§ 94, 96, 107, 136, 142, 151, 177, 183, 193. Эл оноосон нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
20. Kilqo müren-*Хилго мөрөн*, la rivière Kilqo /勤<sup>ᠬ</sup>勒<sup>ᠬ</sup>豁<sup>ᠤ</sup>洩<sup>ᠤ</sup>-k'ín l(è) ħuō mù ríén/. §§ 105, 109. Энэ нь өнөөгийн ОХУ-ын нутаг дэвсгэрт орших Хялга гол бөгөөд орчин цагийн франц хэлнээ уг голыг **Khilok** гэдэг байна. Орчуулагчид уг голын нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
21. Kimurqa qoroqan-*Химурга горхи*, le ruisseau Kimurqa /乞<sup>ᠬ</sup>洩<sup>ᠤ</sup>兒<sup>ᠮ</sup>合<sup>ᠬ</sup>豁<sup>ᠤ</sup>羅<sup>ᠤ</sup>罕<sup>ᠤ</sup> -k'ī mù ér ħā ħuō rá ħān /. §§88, 107. Уг горхи нь Онон голын урсац бөгөөд нэрийг нь франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
22. Kišil Baš na'ur-*Хишилбаши нуур* (Кызылбаш), Le lac Tête-Rouge /乞<sup>ᠬ</sup>濕<sup>ᠤ</sup>勒<sup>ᠤ</sup>巴<sup>ᠰ</sup>失<sup>ᠤ</sup> 納<sup>ᠤ</sup>渥<sup>ᠤ</sup>兒<sup>ᠷ</sup>-k'ī shī l(è) pā shī nà wú ér/. §§158, 177. Энэ нь өнөөгийн Шинжаан-Уйгурт байдаг Өрөнгө нуур бөгөөд франц хэлнээ уг нуурын нэрийг **улаан** (=тур. Kišil) **толгой** (=тур. Baš) хэмээн үгчлэн орчуулжээ.
23. Kōkō na'ur-*Хөх нуур*, Le lac Bleu /闊<sup>ᠬ</sup>闊<sup>ᠤ</sup>納<sup>ᠤ</sup>渥<sup>ᠤ</sup>兒<sup>ᠷ</sup> -k'uò k'uò nà wú ér/. §§89, 122, 269. Судлаачид уг нуурыг өнөөгийн Хэнтий аймагт орших Хар зүрхний Хөх нуур хэмээн тогтоожээ. Нуурын нэрийг франц хэлнээ үгчлэн орчуулсан байна.
24. Kōlen na'ur-*Хөлөн нуур*, Le lac Kōlün /闊<sup>ᠬ</sup>洩<sup>ᠤ</sup>納<sup>ᠤ</sup>渥<sup>ᠤ</sup>兒<sup>ᠷ</sup>-k'uò lién nà wú ér/. §53. Уг нуур нь өнөөгийн Өвөр Монголын Хөлөнбуйрт орших бөгөөд нуурын нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.

25. Na'u müren-*Нагу мөрөн*, la rivière Nonni /納浯沐<sup>ᠰ</sup>漣-nà wú mù rién /. §253. Сунгарид цутгадаг Ноон мөрний нэрийг франц хэлнээ тогтсон хувилбараар нь орчуулсан байна.
26. Nekün usun-*Нэгүн ус*, la rivière du Servant /涅坤兀孫-niè k'ün wù sūn/. §188. Орчуулагчид **Нэгүн** гэдэг үгийг *Servant* ‘зарц, боол’ хэмээн үгчлэн орчуулсан байна<sup>41</sup>. *Rivière* ‘гол’ гэдгийн тухайд дээрээс үзнэ үү.
27. Onan müren-*Онон мөрөн*, La rivière Onan /斡難沐<sup>ᠰ</sup>漣 -uò nán mù rién/. §§1, 24,30, 32, 50, 54, 55, 72, 75, 81, 84, 88, 106, 116, 129, 130, 136, 144, 202. Уг мөрний нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
28. Orqon-*Орхон*, L'Orqon /斡兒洄-uò ér huán/. §§105, 112, 195. Уг мөрний нэрийг франц хэлнээ үсэгчлэн буулгасан байна.
29. Ölegei bulaq-*Өлгий булаг*, la Source-du Berceau /斡列該不<sup>刺</sup>合-uò liè kāi pù lā hǎ/. §128. Судлаачид уг булгийн байршлыг нарийвчлан тогтоолгож чадаагүй байна. Орчуулагчид уг оноосон нэрийг франц хэлнээ орчуулахдаа үгчлэн **Berceau** ‘өлгий’ гэж орчуулжээ.
30. Qačir usun-*Хачир-Ус*, la rivière Croûte-de-Glace /<sup>中</sup>合池<sup>ᠰ</sup>兒兀孫-hǎ ch'í ér wù sūn/. §§194, 195. Монголын нэрт эрдэмтэн Х. Пэрлээ уг голын байршлыг Хангайн бүсийн 47° N 102° E байрлах Хоросого хэмээх Тамирын голын цутгал хэмээн тогтоожээ. Уг оноосон нэрийг франц хэлнээ **Croûte-de-Glace** ‘мөсөн бүрхүүл’ гэж орчуулжээ. Гэтэл нэрт судлаач И. де Рахевильц уг нэрийн утгыг **mule** ‘луус’ гэж тайлбарласан бөгөөд бид уг тайлбартай санал нийлж байна.
31. Qalqa-*Халх гол*, la rivière du Bouclier /<sup>中</sup>合勒<sup>中</sup>合-hǎ l(è) hǎ/. §§175, 176, 208. Голын нэрийн утгыг **халхавч, хамгаалалт** хэмээн үзэж франц хэлнээ **Bouclier** ‘бамбай’ хэмээн үгчлэн орчуулжээ.
32. Qara se'ül-*Хар сүүл*, le cours de la Queue-Noire /<sup>中</sup>合<sup>ᠰ</sup>刺薛兀勒-hǎ rā siè wù l(è)/. §§ 159, 177. Уг оноосон нэрийг франц хэлнээ үгчлэн орчуулжээ: **Queue** ‘сүүл’ **Noire** ‘хар’.
33. Qaradal huja'ur-*Хардал узуур*, les sources de la Qaratal/<sup>中</sup>合<sup>ᠰ</sup>刺苔勒忽札兀<sup>ᠰ</sup>兒-hǎ rā tā l(è) hū chá wù ér/. §197. Судлаачид уг газрын нэр, байршил зэргийг өөр өөрөөр тайлбарладаг бөгөөд нэгдсэн нэг саналд хүрээгүй байна. Франц орчуулгын тухайд уг нэрийг үсэгчлэн буулгасан байна.
34. Selengge müren-*Сэлэнгэ*, La Selenga /薛凉格沐<sup>ᠰ</sup>漣-siē liáng ké mù rién/. §§105, 109, 110, 112, 144, 152, 162, 219. Уг мөрний нэрийг франц хэлнээ тогтсон хувилбараар нь буулгасан байна.
35. Senggür qoroqan-*Сэнгүр горхи*, le ruisseau Senggür /桑沽<sup>ᠰ</sup>兒<sup>中</sup>豁<sup>ᠰ</sup>羅<sup>中</sup>罕-sāng kū er huō r á hān /. §§89, 93, 94, 96, 122. Энэ нь өнөөгийн Хэнтий аймгийн Хөдөө аралд байдаг Ар цэнхэрийн ус хэмээх газар бөгөөд франц орчуулгад уг нэрийг үсэгчлэн буулгасан байна.

<sup>41</sup> Н. Мөнх, Монголын нууц товчооны хүний нэрийн франц орчуулга, УБ., 2020, т. 70, Нэхүн тайш гэдгийг үзнэ үү.

36. Šin müren-*Шин мөрөн*, le fleuve Indus, l'Indus /申沐<sup>ᠰ</sup>漣-shēn mù rién/. §§257, 264. Синд гэдэг нь Инд мөрний санскрит нэр бөгөөд франц орчуулгад уг нэрийг тогтсон хувилбараар нь орчуулсан байна.
37. Šisgis-*Шисгис*, la rivière Sisgid /失思吉思-shǐ sī kí si/. §144. Судлаач И. де Рахевильц уг голыг Хөвсгөл нуураас баруун зүгт оршдог хэмээжээ. Франц орчуулгад уг нэрийг үсэгчлэн буулгасан байна.
38. Soqoq usun-*Согог ус*, la rivière Glaciale /潰<sup>中</sup>豁<sup>黑</sup>兀孫-suǒ hūō h(ei)wù sūn/. §§158, 177. Түр. *soqoq* гэдэг нь хүйтэн гэсэн утгатай бөгөөд орчуулагчид уг голын нэрийг франц хэлнээ орчуулахдаа *Glaciale* ‘тэсгэм хүйтэн’ хэмээн үгчлэн орчуулсан байна.
39. Tamir-*Тамир*, la rivière Tamir /塔米<sup>ᠰ</sup>兒-t'ǎ mǐ ér/. §§195, 196. Уг голын нэр ‘гол судас, улаан гол’ гэсэн утгатай бөгөөд франц хэлнээ нэрийг үсэгчлэн буулгасан байна.
40. Tana qoroqan-*Тана горхи*, le ruisseau de Nacre /塔<sup>中</sup>豁<sup>ᠰ</sup>羅<sup>中</sup>罕-t'ǎ nà hūō rá hān/. §107. *Тана* ‘хясааны дотор талын гоёл чимэглэлд хэрэглэдэг солонгорсон өнгөт давхарга’ гэдгийг үгчилж *Nacre* хэмээн орчуулжээ.
41. Tawur müren-*Таур мөрөн*, La rivière T'ao-er /討浯<sup>ᠰ</sup>兒沐<sup>ᠰ</sup>漣-t'ǎo wú ér mù rién/. §253. Таоэрхэ хэмээх энэ мөрөн нь Ноон мөрөнд цутгадаг бөгөөд франц орчуулгад уг нэрийг тогтсон хувилбараар нь буулгасан байна.
42. Tenggeli[k] qoroqan-*Тэнхлэг горхи*, la rivière Serpentine /騰格里<sup>中</sup>豁<sup>ᠰ</sup>羅<sup>中</sup>罕-t'éng ké lí hūō rá hān/. §100. Орчуулагчид И. де Рахевильц нарын нэгэн адил *Tünggelik - Tenggeli[k]* гэдэг нь нэг нэр хэмээн үзээд ийн үгчлэн орчуулжээ.
43. Tüngge qoroqan-*Түнгэ горхи*, le Serpentin /統格<sup>中</sup>豁<sup>ᠰ</sup>羅<sup>中</sup>罕-t'üng ké hūō rá hān/. §177. Орчуулагчид уг голын нэрийн утгыг *гогцоо*, *дэгээ* гэж үзээд Франц хэлнээ ийн утгачлан орчуулжээ. Бид уг голын нэрийн утгыг *түнгэ*<sup>42</sup> хэмээн үзэж байгаа тул энэ тохиолдолд уг нэрийг буруу орчуулсан хэмээн үзэж байна.
44. Tünggelik qoroqan-*Түнхэлиг горхи*, La Serpentine /統格黎克<sup>中</sup>豁<sup>ᠰ</sup>羅<sup>中</sup>罕-t'üng ké lí k(è) hūō rá hān/. §§5, 28, 30, 32, 35, 107. Уг нэрийг франц орчуулгад утгачлан орчуулжээ, нэрийн орчуулгын тухайд дээрээс харна уу.
45. Tu'ula-*Туул*, la Toula /土兀刺-t'ǔ wù lā/. §§96, 104, 115, 164, 177, 264. Орчуулагчид уг нэрийг франц хэлнээ тогтсон хувилбараар нь орчуулсан байна.
46. Ula müren-*Ула мөрөн* (Сунгари мөрөн), la rivière Sungari /浯刺沐<sup>ᠰ</sup>漣-wú lā mù rién/. §253. Уг оноосон нэрийг франц хэлнээ тогтсон нэрээр нь орчуулсан байна.
47. Ulja-*Улз*, la rivière Ulja /浯勒札 -wú l(è) chá/. §133. Голын нэрийг франц хэлнээ галиглан буулгасан байна.

<sup>42</sup> Гол нуурын хужир мараа, дэрс бүхий овон товон газар. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичгийг үзнэ үү.

48. Urši'un müren-Ориуун мөрөн, La rivière Ursi'un /兀兒失温沐漣-wù ér shǐ uen mù rién/. §53. Хөлөн нуурт цутгадаг уг голын нэрийг франц орчуулгад үсэгчлэн буулгасан байна.
49. Ürünggü-Үрүнгү, la rivière Ürünggü /兀瀧古-wù róng kǔ /. §§158, 177. Уг голын нэрийг хэдий түрэг гаралтай үг хэмээн үздэг авч нэрийн утгыг цаашид нягтлах шаардлагатай байна. Франц орчуулгын тухайд уг нэрийг үсэгчлэн буулгасан байна.

### Дүгнэлт

МНТ-д нуур, мөрөн, гол, горхи, ус зэрэг бүхий 49 оноосон нэр байснаас Мари-Доминик Эвен, Родика Поп нар 19 нэрийг үгчилж, 14 нэрийг үсэгчилж, 5 нэрийг галиглаж, 11 нэрийг франц хэлнээ тогтсон хувилбараар нь орчуулсан байна.

Бид Түнгэ хэмээх оноосон нэрийн утгын тайлбарыг эргэлзээтэй хэмээн үзэж өөрсдийн зүгээс санал дэвшүүлсэн болно. Мөн Хэрлэн, Орхон, Хилхо зэрэг хэд хэдэн голын нэрийг франц хэлтэн уншигчдад хүртээмжтэй болгох үүднээс франц хэлнээ тогтсон хувилбараар нь буулгах нь зүйтэй хэмээн үзэж байна.

### Номзүй

1. Гаадамба Ш., 1990. *Монголын нууц товчооны судлалын зарим асуудал*, Улсын хэвлэлийн газар, УБ.
2. Дашцэдэн Т., 2009. *Монголын нууц товчоон -ы галиг*, Битпресс ХХК, УБ.
3. Лувсанданзан 1990. *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оривой*, УБ.
4. Лувсандорж Ж., 2014. *Монголын нууц товчоон* (Монгол улсын Нууц түүх), “Бэмби сан” ХХК, УБ.
5. Мостаэрт А., 2010. *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухай*, УБ.
6. МУ-ын ШУА, Түүхийн хүрээлэн, 2012. *Монгол улсын Угсаатны зүй*, III боть, Эрхэлсэн С. Бадамхатан, Г. Цэрэнханд, Адмон, УБ.
7. Ожегов С. И., 1981. *Словарь русского языка*, Москва.
8. Х. Пэрлээ, *Монголын нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь*, УБ., 1958.
9. Пэрлээ Х. 1968. *Монгол газрын түүхэн нэрийн нэгэн зүйл*, Монгол орны газар зүйл асуудал. УБ., - № 8.
10. Равдан Э., 2016. *Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр*, УБ.
11. Сумъяабаатар Ц., 1990. *Монголын нууц товчооны үсгийн галиг*, УБ.
12. Чоймаа Ш., 2011. *Монголын нууц товчоо*, Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Мөнхийн үсэг ХХК., УБ.

### Латин үсгээр:

1. de Rachewiltz I., 2004. [\*The Secret History of the Mongols: A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century\*](#), Brill Leiden-Boston, Vol. I, II.  
-1972. *Index to the Secret history of the Mongols*, Indiana University Publications.
2. Marie-Dominique Even et Rodica Pop, 1994. *Histoire secrète des Mongols*, Connaissance de l'Orient, collection UNESCO d'œuvres représentatives, Gallimard, Paris.
3. Jarring G., *Some Notes of Central Asian Turkic Place Names* // Bulletin of the Geological Society.
4. Pelliot P., 1949. *Histoire secrète des Mongols*, restitution du texte mongol et traduction française des chapitres I à VI, Librairie d'Amérique et d'Orient, Adrien-Maisonneuve, Paris.
5. Robert P., 2010. *Le Nouveau petit Robert de la langue française*, Paris.